

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ 5 САРД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН

Сургалт зохион байгуулах үндэслэл:

Монгол Улсын “Төрийн албаны тухай хууль”, Засгийн газрын 2019 оны 33 тоот “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах” тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тоот “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгавар, байгууллагын 2023 оны “Ажилтнуудын ёс зүй, сахилга, хариуцлага болон байгууллагын соёл, үйлчилгээг сайжруулах” зорилгыг хэрэгжүүлэхэд оршино.

Сургалтын зорилго:

Ажилтнуудын ёсзүй, хөдөлмөрийн сахилга, хариуцлага, байгууллагын соёл, үйлчилгээг сайжруулах, ажилтнуудын хууль эрхзүйн мэдлэгийг сайжруулах, гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх;

Хамрах хүрээ: Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт ажилтнууд;

Сургалт зохион байгуулах хугацаа: 2023 оныг дуустал

Зохион байгуулагдсан сургалтууд:

1. 2023.01.06-ны өдөр ЗХНА-наас сэтгэл зүйч Г.Наранбаатар Захиргааны тасгийн 30 албан тушаалтан, мэргэжилтэнд “Ур чадвар-хандлагын ур чадвар, мэдээлэл боловсруулах ур чадвар, мэдээлэл дамжуулах ур чадвар” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын дараа

2. 2023.03.11-ний өдөр Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Сувилахуйн алба үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн ажлын хүрээнд "СУВИЛАХУЙН ЁС ЗҮЙ" сургалтыг 362 сувилагч, тусгай мэргэжилтэнд зохион байгуулсан.




Зураг. Сургалтын явц

3. 2023.03.16-ны өдөр Эгүүшин академийн үүсгэн байгуулагч Т.Гаравхүү Захиргааны тасгийн мэргэжилтнүүдэд “Та ирээдүйгээ бэлдэж эхэлсэн үү?” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явц

4. 2023.03.29-ний өдөр Олон улсын эмч нарын баярын өдрийг тохиолдуулан УНТЭ-ийн нийт эмч нарт АШУҮИС-ийн доктор, профессор Б.Мөнхбатаар “Мэргэжлийн болон академик ур чадварын тухай” тухай сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явц

5. 2023.04.18-ны өдөр байгууллагын ерөнхий захирлаар батлагдсан “Сэтгэлтэй ажилтан” сэдэвт сургалтын удирдамжийн дагуу УНТЭ-ийн нийт үйлчлэгч нарт Монголын лекторуудын холбооны гишүүн, Сургагч багш-доктор Б.Гансүхтэй хамтран

сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явц

6. 2023.04.27-ны өдөр байгууллагын ерөнхий захирлаар батлагдсан “Манлайлал” сэдэвт сургалтын удирдамжийн дагуу УНТЭ-ийн Захиргааны тасгийн ажилтнуудад сургалтыг АШУҮИС-ийн сургалт 139 тоот танхимд зохион байгуулсан. Сургалтыг Монголын лекторуудын холбооны гишүүн, Сургагч багш-доктор Б.Гансүх удирдан явуулав.




Зураг. Сургалтын явц

7. Байгууллагын ерөнхий захирлаар батлагдсан “Стресс ба сэтгэлийн гал” сэдэвт сургалтын удирдамжийн дагуу 2023.05.16-ны өдөр УНТЭ-ийн нийт үйлчлэгч нарт сургалтыг эмнэлгийн 4-р давхрын хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтыг Сувилахуйн албаны аргазүйч, Зөвлөх зэрэгтэй сувилагч, АШУҮИС-ийн Харилцааны ур чадварын гэрээт багш П.Наранцэцэг удирдан явуулав.



Зураг. Сургалтын явц

8. 2023.05.17-ны өдөр УНТЭ-ийн нийт эмч нарт зөрчлийн тухай хууль, эрхзүйн сургалтыг эмнэлгийн 4-р давхрын хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтыг Сүхбаатар дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Н.Дамбадаржаа Зөрчлийн тухай хуульд заасан Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал" сэдвээр удирдан явуулав. (УНТЭ болон СБД-ийн прокурорын газрын 2023.05.15-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу)



Зураг. Сургалтын явц

9. Байгууллагын ерөнхий захирлаар батлагдсан “Манлайлагч” сэдэвт сургалтын удирдамжийн дагуу 2023.05.18-ны өдөр УНТЭ-ийн Захиргааны тасгийн ажилтнуудад сургалтыг эмнэлгийн 4-р давхрын хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтыг Монголын лекторуудын холбооны гишүүн, Сургагч багш-доктор Б.Гансүх удирдан явуулав.



Зураг. Сургалтын явц

10. 2023.05.26-ны өдөр Сүхбаатар дүүргийн прокурорын газрын сургалтын танхимд УНТЭ-ийн дэмжих үйлчилгээний ажилчдад Зөрчлийн тухай хуульд заасан “Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр Сүхбаатар дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Н.Дамбадаржаа, “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр хяналтын прокурор М.Гансувд нар тус тус сургалтын зохион байгуулсан. (УНТЭ болон СБД-ийн прокурорын газрын 2023.05.15-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу)



Зураг. Сургалтын явц

2023.05.30
Захиргаа, хүний нөөцийн алба
УНТЭ-ийн дэргэдэх Ёсзүйн салбар хороо